



VI/2022


Тархаасан: 2022 оны 7 дугаар сарын 18



Нас гүйцсэн эр хонины үнэ Орхон аймагт 280.0 мянган төгрөгт хүрлээ


Малын зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2022 оны 6 дугаар сард атны үнэ 1.5 сая төгрөг болж, өмнөх сараас 7.2 мянган төгрөгөөр, эр хонины үнэ 234.3 мянган төгрөг болж, өмнөх сараас 2.8 мянган төгрөгөөр тус тус буурсан байна. Харин соёолон үрээнийх 1.2 сая төгрөг болж, өмнөх сараас 12.0 мянган төгрөг, хязаалан гуных 1.4 сая төгрөг болж, өмнөх сараас 10.8 мянган төгрөгөөр, эр ямааны үнэ 161.5 мянган төгрөг болж, өмнөх сараас 200 төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 1. НАС ГҮЙЦСЭН МАЛЫН ДУНДАЖ ҮНЭ (сум), мянган төгрөгөөр




Эр хонины үнэ 2022 оны 6 дугаар сард Орхон аймагт 280.0 мянган төгрөг болж, өмнөх сараас 30.0 мянган төгрөгөөр өссөн байна. Хэнтий аймагт 177.1 мянган төгрөг болж, өмнөх сараас 8.5 мянган төгрөгөөр буурсан байна.

ЗУРАГ 2. НАС ГҮЙЦСЭН ЭР ХОНИНЫ ДУНДАЖ ҮНЭ, 2022 оны 6 дугаар сард, мянган төгрөг




Үхрийн 2 метрээс дээш урттай шир 2022 оны 6 дугаар сард 4.8 мянган төгрөг болж, өмнөх сараас 1.0 мянган төгрөгөөр буурсан байна. Харин ямааны цагаан ноолуур 1 кг-ын үнэ 89.6 мянган төгрөг болж, өмнөх сараас 3.5 мянган төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 3. МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 6 дугаар сард, төгрөг



Цагаан ноолуурын 1 кг-ын үнэ 2022 оны 6 дугаар сард Улаанбаатар хотод 100.0 мянган төгрөг байгаа бол Дорнод аймагт 50.0 мянган төгрөг байна.

ЗУРАГ 4. ЦАГААН НОЛУУРЫН 1 КГ-ЫН ДУНДАЖ ҮНЭ, 2022 оны 6 дугаар сард, төгрөг



Хивэгний (25 кг) үнэ 2022 оны 6 дугаар сард Завхан аймагт хамгийн их буюу 24.5 мянган төгрөг байгаа бол Төв аймагт хамгийн бага буюу 11.0 мянган төгрөг байна.

Тооцох аргачлал:

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгааг сар бүр, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн худалдааны цэгүүдээс авч нэгтгэн сарын дундаж үнийг арифметик дунджаар тооцно.



Эх үүсвэр:

ҮСХ, ХАА-н бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээ

Мэдээлэл авах холбоос

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 8 дугаар сарын 14

Эдийн засгийн статистикийн газрын дарга

А.Дэмбэрэл

Утас : (976-51)-329271

Эдийн засгийн статистикийн газрын

Үнийн статистикийн хэлтсийн гэрээт

ажилтан Г.Ануужин

Утас : (976-51)-261559

